



Улс орон нэгдэл түүхийн хэвлэл  
2010 оны 02 дугаар сарын 26  
№08 /629/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хууль

277

**Хөрөнгийн үнэлгээний тухай**

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

291

**Монгол Улсын одон, медалиар  
шагнах тухай**

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

295

**Журам батлах тухай**



## ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

76.	Хөрөнгийн үнэлгээний тухай	277
-----	----------------------------	-----

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

77.	Монгол Улсын одон, медалиар шагнах тухай	
	Дугаар 173	291

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

78.	Журам батлах тухай	Дугаар 362	295
-----	--------------------	------------	-----

79.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 364	300
-----	------------------------	------------	-----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 01 дүгээр  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

## 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөрөнгийн үнэлгээ хийх эрх зүй, зохион байгуулалтын үндсийг тогтоож, энэ чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## 2 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомж

2.1.Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

<sup>1</sup>Монгол улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Иргэний хууль – “Төрийн мэдээлэл” эхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эхтгэлийн 2001 оны 6

дугаарт нийтлэгдсэн.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."үнэлгээчин" гэж хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

3.1.2."үйчлүүлэгч" гэж хөрөнгийн үнэлгээ хийлгэж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдийг;

3.1.3."хөрөнгийн үнэлгээний зүйл" гэж тодорхой үнэ цэнээр үнэлэгдэх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн өмчлөх эрхийг;

3.1.4."хөрөнгийн үнэлгээ хийх" гэж хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтооход чиглэсэн үнэлгээчний хараат бус үйл ажиллагааг;

3.1.5."үнэ цэнэ" гэж хөрөнгийн үнэлгээ хийсний үр дүнд тогтоосон хөрөнгийн үнэлгээний зүйлийн тухайн үеийн мөнгөөр илэрхийлэгдэх үнийн дүнг;

3.1.6."хөрөнгийн үнэлгээний суурь" гэж хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтооход баримталсан зах зээлийн ба зах зээлийн бус үнийн талаархи үндэслэлийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ**

### **4 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийхэд баримтлах зарчим**

4.1.Хөрөнгийн үнэлгээ хийхэд дараахь зарчмыг баримтална:

4.1.1.хараат бус байх;

4.1.2.иргэн, байгууллагын нууцыг хадгалах;

4.1.3.шударга байх;

4.1.4.хууль тогтоомжид нийцсэн байх.

4.2.Хөрөнгийн үнэлгээ хийхэд аливаа этгээд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

4.3.Үнэлгээчин хөрөнгийн үнэлгээ хийх явцад олж авсан үйлчлүүлэгчийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахыг



хориглоно.

4.4.Хөрөнгийн үнэлгээ хийхэд Олон улсын үнэлгээний стандартын хорооноос баталсан олон улсын үнэлгээний стандарт, энэ хуулийн 4.5, 8.2-т заасан хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, аргачлалыг удирдлага болгоно.

4.5.Стандартчиллын төв байгууллага нь хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартыг олон улсын үнэлгээний стандартын зарчим болон энэ хуульд нийцүүлэн батална.

### **5 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл**

5.1.Хөрөнгийн үнэлгээг дараахь үндэслэлээр хийнэ:

5.1.1.үнэлгээчин болон үйлчлүүлэгч харилцан тохиролцсон;

5.1.2.хуульд тусгайлан заасан тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрээр.

### **6 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ**

6.1.Үйлчлүүлэгч болон үнэлгээчин харилцан тохиролцсон бол хөрөнгийн үнэлгээг гэрээний үндсэн дээр хийнэ.

6.2.Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээг бичгээр байгуулна.

6.3.Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээнд дараахь зүйлийг тусгана:

6.3.1.хөрөнгийн үнэлгээний зориулалт;

6.3.2.хөрөнгийн үнэлгээний зүйл, түүний шинж;

6.3.3.талуудын эрх, үүрэг;

6.3.4.үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан

тухай мэдээлэл;

6.3.5.хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлс;

6.3.6.хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх

журам.

6.4.Үнэлгээчин хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ, хөрөнгийн үнэлгээний тайлан, түүнд хавсаргасан бусад баримт бичгийг архивын нэгж бүрдүүлэн 5-аас доошгүй жил хадгална.

### **7 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийх бэлтгэл ажил**

7.1.Хөрөнгийн үнэлгээ хийх бэлтгэл ажил нь дараахь

шаардлагад нийцсэн байна:

7.1.1.хөрөнгийн үнэлгээ хийх гэрээг үйлчлүүлэгчтэй байгуулсан байх;

7.1.2.хөрөнгийн үнэлгээний стандарт, аргачлал, дүрэм, журам, норм, норматив болон шаардлагатай бусад материалыг бэлтгэсэн байх;

7.1.3.хөрөнгийн үнэлгээ хийх төлөвлөгөө, хуваарийг боловсруулж, баталсан байх;

7.1.4.хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардагдах баримт материалыг үйлчлүүлэгчээс гаргуулан авсан байх;

7.1.5.хөрөнгийн үнэлгээ хийхэд ашиглаж байгаа мэдээллийн сан болон үйлчлүүлэгчээс ирүүлсэн тоо, мэдээг дахин хянаж, магадлан шинжилсэн байх.

## **8 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийх арга, аргачлал**

8.1.Хөрөнгийн үнэлгээг тухайн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, зориулалтыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн, орлогын аргуудыг хослуулан, олон улсын болон хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, энэ хуулийн 8.2-т заасан хөрөнгийн үнэлгээний аргачлалд нийцүүлэн тодорхойлно.

8.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дангаараа, эсхүл төрийн холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, зориулалтад нийцсэн хөрөнгийн үнэлгээний аргачлалыг баталж, мөрдүүлнэ.

## **9 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээний тайлан**

9.1.Хөрөнгийн үнэлгээний тайлан нь хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнэ, түүнийг тогтоосон үндэслэл, нотолгоог агуулсан үндсэн баримт бичиг байна.

9.2.Хөрөнгийн үнэлгээний тайлан нь дараахь шаардлагад нийцсэн байна:

9.2.1.хөрөнгийн үнэлгээний суурийг тодорхойлохдоо тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлогт үндэслэсэн байх;

9.2.2.хөрөнгийн үнэлгээ хийх явц дахь хөрөнгийн үнэлгээний стандарт, дүрэм, журам, норм, нормативыг зөрчсөн аливаа тохиолдлын талаар тэмдэглэсэн байх;

9.2.3.хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ

зохих үндэслэл бүхий, тодорхой байх.

### 9.3.Хөрөнгийн үнэлгээний тайланд дараахь зүйлийг тусгана:

9.3.1.үнэлгээчний нэр, хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл/цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/-ийн дугаар, тусгай зөвшөөрлийн хугацаа, үнэлгээчний хариуцлагын даатгалын талаархи мэдээлэл;

9.3.2.үйлчлүүлэгчийн нэр, хаяг, регистрийн дугаар болон шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

9.3.3.хөрөнгийн үнэлгээ хийсэн үндэслэл, зориулалт;

9.3.4.хөрөнгийн үнэлгээ хийсэн хугацаа болон тайлангийн он, сар, өдөр;

9.3.5.хөрөнгийн үнэлгээний зүйлийн төрөл, түүний шинж байдлын тодорхойлолт;

9.3.6.хөрөнгийн үнэлгээний зүйлийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаархи мэдээлэл;

9.3.7.хөрөнгийн үнэлгээний тайлангийн хамрах хүрээ, хязгаарлах нөхцөл;

9.3.8.хөрөнгийн үнэлгээ хийхэд ашигласан баримт, мэдээлэл, нотолгоо, шинжилгээ, үнэлгээний тооцоолол, түүний үндэслэл;

9.3.9.хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтооход хэрэглэсэн арга, горим, тэдгээрийн нийцтэй байдал;

9.3.10.хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ;

9.3.11.хөрөнгийн үнэлгээг энэ хуульд заасан стандарт, аргачлалын дагуу хийсэн талаархи үнэлгээчний мэдэгдэл.

9.4.Хөрөнгийн үнэлгээний тайланд үнэлгээчин гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан байна.

### 10 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлс

10.1.Үнэлгээчин хөрөнгийн үнэлгээ хийсэн бол үйлчлүүлэгчээс үйлчилгээний хөлс авна.

10.2.Хөрөнгийн үнэлгээг энэ хуулийн 5.1.1-д заасан үндэслэлээр хийх бол үйлчилгээний хөлсийг талуудын хооронд байгуулах гэрээгээр тогтооно.

10.3.Хөрөнгийн үнэлгээг энэ хуулийн 5.1.2-т заасан үндэслэлээр хийх бол үйлчилгээний хөлсийг мөн хуулийн 10.4-т заасан жишгийг харгалзан тогтооно.

10.4.Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлсний жишгийг санхүү,

төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

### **11 дүгээр зүйл. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг**

11.1. Үйлчлүүлэгч дараахь эрх, үүрэгтэй:

11.1.1. үнэлгээнийг сонгох;

11.1.2. үнэлгээний үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад гомдол гаргах;

11.1.3. хөрөнгийн үнэлгээний тайлантай танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл танилцсанаас хойш 30 хоногийн дотор гомдлоо энэ хуулийн 25.2-т заасан Мэргэжлийн зөвлөлд гаргах;

11.1.4. хөрөнгийн үнэлгээний тайлангийн талаар үнэлгээчнээс тайлбар авах;

11.1.5. хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай үнэн зөв баримт, мэдээллээр үнэлгээчнийг хангах;

11.1.6. хуульд заасан бусад эрх, үүрэг.

11.2. Үйлчлүүлэгч энэ хуулийн 11.1.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг үнэлгээчин хариуцахгүй.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ҮНЭЛГЭЭЧИН**

### **12 дугаар зүйл. Үнэлгээчний ёс зүйн дүрэм**

12.1. Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага үнэлгээчний ёс зүйн дүрмийг баталж, мөрдүүлнэ.

12.2. Үнэлгээчний ёс зүйн дүрэм нь олон улсын үнэлгээний стандартад нийцсэн байна.

### **13 дугаар зүйл. Үнэлгээчний эрх**

13.1. Үнэлгээчин дараахь эрх эдэлнэ:

13.1.1. хөрөнгийн үнэлгээний олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн энэ хуульд заасан журмын дагуу хөрөнгийн үнэлгээ хийх аргыг бие даан сонгох;

13.1.2. хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай үнэн зөв

баримт, мэдээллээр хангахыг үйлчлүүлэгчээс шаардах;

13.1.3.үйлчлүүлэгч хөрөнгийн үнэлгээний зүйлийн тухай шаардлагатай мэдээллээр хангаагүй, гэрээнд заасан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй бол хөрөнгийн үнэлгээ хийхээс татгалзах;

13.1.4.хөрөнгийн үнэлгээ хийхэд бусад үнэлгээчин болон мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр татан оролцуулах;

13.1.5.хууль тогтоомжид заасан бусад эрх.

13.2.Үнэлгээчин үйл ажиллагаагаа аж ахуйн нэгжийн хэлбэрээр явуулж болно.

#### 14 дүгээр зүйл.Үнэлгээчний үүрэг

14.1.Үнэлгээчин дараахь үүрэг хүлээнэ:

14.1.1.үнэлгээчний өс зүйн дүрмийг сахин биелүүлэх;

14.1.2.хөрөнгийн үнэлгээ хийх явцдаа үйлчлүүлэгч болон гуравдагч этгээдээс авсан баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангах;

14.1.3.өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөх;

14.1.4.хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах;

14.1.5.үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх;

14.1.6.үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

14.1.7.хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын гишүүн байх;

14.1.8.хөрөнгийн үнэлгээний тайланг энэ хуулийн 9.2-т заасан шаардлагад нийцүүлэн гаргах;

14.1.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

#### 15 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийж болохгүй нөхцөл

15.1.Дараахь этгээдийн хөрөнгийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг үнэлгээчин хүлээн авахаас татгалзана:

15.1.1.өөрийн ажилладаг хуулийн этгээд болон сүүлийн хоёр жилийн дотор хамтран ажиллаж байсан иргэн, хуулийн этгээдийн;

15.1.2.сүүлийн нэг жилийн дотор өөрөө эд хөрөнгийн талаар /компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэг, эсхүл зээл, төлбөр болон хөрөнгө оруулалтын талаар харилцаатай/





холбоотой байсан буюу холбоотой байгаа иргэн, хуулийн этгээдийн;

15.1.3.ойрын төрөл, садан /эцэг, эх, нөхөр, эхнэр, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү нар/ нь эрх бүхий албан тушаалтан /төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн/-аар ажилладаг хуулийн этгээдийн;

15.1.4.үнэлгээчний санхүүгийн тайланд аудит хийсэн хуулийн этгээдийн;

15.1.5.үнэлгээчинд эрх зүйн туслалцаа үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийн;

15.1.6.хуульд заасан бусад тохиолдолд.

15.2.Үнэлгээчин өөрийнхөө хөрөнгөд үнэлгээ хийж болохгүй.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

#### **ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ**

##### **16 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих**

16.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараахь байдлаар хяналт тавина:

16.1.1.хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

16.1.2.хөрөнгийн үнэлгээний сургалтын жишиг хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;

16.1.3.үнэлгээчнийг сонгон шалгаруулах журмыг баталж, мөрдүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

16.1.4.хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

16.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

##### **17 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох журам**

17.1.Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.

##### **18 дугаар зүйл.Үнэлгээчний сонгон шалгаруулалтыг зарлах**

18.1.Үнэлгээчний сонгон шалгаруулалт /цаашид "сонгон



шалгаруулалт" гэх/-ыг жилд нэгээс доошгүй удаа товлон зарлана.

18.2.Сонгон шалгаруулалтын товыг шалгаруулалт эхлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

18.3.Сонгон шалгаруулалтын товд бүртгэх, шалгаруулалтыг явуулах хугацаа, газар, сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, сонгон шалгаруулалтын шалгалтын хамрах хүрээ зэргийг заасан байна.

### **19 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид тавих шаардлага**

19.1 Дараахь шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй:

19.1.1.инженер, эдийн засаг, бизнес, санхүү, нягтлан бодох, хууль зүйн аль нэг чиглэлээр дээд боловсролтой;

19.1.2.мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан;

19.1.3.хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд 3-аас доошгүй жил оролцсон, хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааны зохих дадлага, туршлагатай;

19.1.4.хөрөнгийн үнэлгээний сургалтад хамрагдан гэрчилгээ авсан;

19.1.5.ял шийтгэлгүй.

### **20 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчийн бүрдүүлэх баримт бичиг**

20.1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгч нь дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

20.1.1.сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл;

20.1.2.Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд гадаад улсын паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичиг, түүний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

20.1.3.Боловсролын зэргийн диплом, түүний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

20.1.4.нийгмийн даатгалын дэвтэр, түүний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

20.1.5.энэ хуулийн 19.1.3-т заасан шаардлагыг хангасныг нотолсон тодорхойлолт;

20.1.6.оролцсон хөрөнгийн үнэлгээний тайлангийн

жагсаалт;

20.1.7.энэхуулийн 19.1.4-т заасан сургалтад хамрагдсаныг нотлох гэрчилгээ, түүний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

20.1.8.ял шийтгэлгүй болохыг нотолсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

20.1.9.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

## **21 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах**

21.1. Сонгон шалгаруулалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 25.1-д заасан хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

21.2. Сонгон шалгаруулалт нь хөрөнгийн үнэлгээ хийх онол, арга зүй, стандарт болон санхүү, өмчийн эрх зүйн мэдлэгийг шалгах аман болон бичгийн шалгалтын хэлбэрээр явагдана.

21.3. Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага энэ хуулийн 21.2-т заасан шалгалтын материалыг урьдчилан бэлтгэж болох бөгөөд энэ нь сонгон шалгаруулалтыг явуулах өдөр, цаг хүртэл байгууллагын нууцад хамаарна.

21.4. Сонгон шалгаруулалтын комисс тусгай зөвшөөрөл хүсэгчийн нэрсийг нууцалсан кодоор дугаарлах бөгөөд сонгон шалгаруулалтын дүнг энэ кодоор ажлын 5 өдөрт багтаан мэдээлнэ.

21.5. Энэ хуулийн 21.4-т заасан код шалгалтын дүн гартал байгууллагын нууцад хамаарна.

21.6. Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүн болон шалгалтын нарийвчилсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **22 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах**

22.1. Тусгай зөвшөөрлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн 3-аас доошгүй жилийн хугацаагаар олгоно.

22.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид гэрчилгээ, тэмдэг олгох бөгөөд гэрчилгээ, тэмдгийн загварыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



22.3.Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1-ээс доошгүй сарын өмнө түүнийг эзэмшигч нь хугацаа сунгуулах өргөдөл гаргах эрхтэй.

22.4.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдөлд дараахь баримт бичгийг хаасаргана:

22.4.1.тусгай зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

22.4.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

22.5.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тусгай зөвшөөрлийг 3 хүртэл жилийн хугацаагаар сунгана.

### **23 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

23.1.Үнэлгээчин энэ хуулийн 9.2, 14.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг 3 хүртэл сарын хугацаагаар түдгэлзүүлнэ.

23.2.Үнэлгээчин эрүүгийн хариуцлагад татагдсан тохиолдолд эрх бүхий байгууллага эцэслэн шийдвэр гаргах хүртэл тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж болно.

23.3.Энэ хуулийн 23.1, 23.2-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг зөвшөөрлийг сэргээнэ.

### **24 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

24.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь тохиолдолд хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

24.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

24.1.2.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

24.1.3.үнэлгээчний ёс зүйн дүрэм болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

24.1.4.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

24.1.5.хөрөнгийн үнэлгээг бодитой бус хийсэн нь шинжээчний дүгнэлтээр тогтоогдсон;



24.1.6.энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй;

24.1.7.үнэлгээчин гэмт хэрэг үйлдсэн тухай шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон.

## ТАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

### 25 дугаар зүйл. Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага

25.1.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага нь үнэлгээчдийг эгнээндээ нэгтгэсэн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага байна.

25.2.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын дэргэд үнэлгээчний мэргэжлийн алдаа гаргасан тухай маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл, үнэлгээчин ёс зүйн алдаа гаргасан тухай холбогдох этгээдээс ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Ёс зүйн зөвлөл тус тус ажиллана.

25.3.Энэ хуулийн 25.2-т заасан Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг мөн хуулийн 8.2-т заасан байгууллага батална.

25.4.Энэ хуулийн 25.2-т заасан Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага батална.

25.5.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар<sup>4</sup> зохицуулна.

### 26 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын бүрэн эрх

26.1.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1.үнэлгээчдийг мэргэжлийн удирдлагаар хангах;

26.1.2.үнэлгээчнийг бэлтгэх, сургах, давтан сургах ажлыг зохион байгуулах;

26.1.3.үнэлгээчний ёс зүйн дүрмийн биелэлтэд хяналт тавих;

26.1.4.үнэлгээчний үйл ажиллагаанд судалгаа, дүгнэлт хийх;

26.1.5.үнэлгээчний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

<sup>4</sup>Төрийн бус байгууллагын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эхтгэлийн 1997 оны 3 дугаарт нийтлэгдсэн

26.1.6.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх;

26.1.7.хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн санг бүрдүүлж, ажиллуулах;

26.1.8.энэ хуулийн 21.1-д заасан сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад оролцох.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **27 дугаар зүйл. Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан**

27.1.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага нь үнэлгээчний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөрөнгийн үнэлгээний зүйлийн зах зээлийн үнэ цэнийг тогтооход ашиглах зорилгоор хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлнэ.

27.2.Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ:

27.2.1.зах зээлийн үнийн судалгаа эрхлэгч байгууллагаас гаргасан мэдээ, мэдээлэл;

27.2.2.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээсэн зах зээлийн үнэ, ханшийн талаархи мэдээ, мэдээлэл;

27.2.3.гишүүн үнэлгээчний хийсэн хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийн талаархи мэдээлэл;

27.2.4.хөрөнгийн үнэлгээнд ашиглаж болох бусад мэдээ, мэдээлэл.

27.3.Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санг гишүүн бус этгээдэд төлбөртэй ашиглуулж болно.

27.4.Энэ хуулийн 4.5, 8.2-т заасан төрийн холбогдох байгууллага хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санг үнэ төлбөргүй ашиглана.

27.5.Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмыг хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага батална.

### **28 дугаар зүйл. Үнэлгээчний хариуцлагын даатгал**

28.1.Үнэлгээчин мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутагдаж хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд алдаа гаргасны улмаас холбогдох этгээдэд



учруулсан хохиролыг нөхөн төлөх зорилгоор үнэлгээчний хариуцлагын даатгалд хамрагдана.

28.2. Үнэлгээчин нь даатгалын байгууллагаа өөрөө сонгоно.

28.3. Үнэлгээчний хариуцлагын даатгалын хураамжийн хэмжээг үнэлгээчин, даатгалын байгууллага харилцан тохиролцож тогтооно.

28.4. Үнэлгээчний хариуцлагын даатгалын хураамжийн доод хэмжээг хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага тогтооно.

### **29 дүгээр зүйл. Үнэлгээчинд хүлээлгэх хариуцлага**

29.1. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомж зөрчсөн үнэлгээчинд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

29.1.1. энэ хуулийн 8.1-д заасны дагуу хөрөнгийн үнэлгээг тодорхойлоогүй, мөн хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

29.1.2. энэ хуулийн 4.3-ыг зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

### **30 дугаар зүйл. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

30.1. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

30.1.1. энэ хуулийн 4.2-т заасныг зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

30.1.2. тусгай зөвшөөрөлгүй этгээд хөрөнгийн үнэлгээ хийсэн бол хууль бусаар олсон орлогыг хурвааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2009 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 173

Улаанбаатар  
хот**Монгол Улсын одон, медалиар шагнах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн арван тавдугаар зүйлийн нэгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Авто замын салбарын үүсэл хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан олон жил үр бүтээлтэй ажилласан доорх нэр бүхий хүмүүсийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

**СҮХБААТАРЫН ОДОН**

1. Бадарын Варнышка - "Эрдэнэ зам" ХК-ийн механизмчин

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН**

1. Дамдингийн Амгалан - "Монголросцветмент" нэгдлийн орлогч дарга
2. Даваажавын Базарпүрэв - "Дархан АЗЗА" ХК-ийн ахмад замчин
3. Сандагийн Ванийхүү - "Миллениум роуд" ХХК-ийн зургийн ерөнхий инженер
4. Түвдэнгийн Давааням - "Дархан АЗЗА" ХК-ийн ерөнхий инженер
5. Дугарын Марсаржав - Хэнтий аймаг дахь зам засвар арчлалтын "Харгуй" ХК-ийн захирал
6. Дамдиндонойн Насанжаргал - АЗХСТ-ийн өндөр настан, зөвлөх инженер
7. Содын Очирбат - Төслийн удирдагч
8. Чанцалын Сүхбаатар - "Эрдэнэ зам" ХК-ийн Ахмадын зөвлөлийн дарга
9. Тогоочийн Тогтох - АЗХСТ-ийн Налайх Тэрэлжийн төлбөр хураах цэгийн ахлагч

**АЛТАН ГАДАС ОДОН**

1. Самбуугийн Авалгаа - "Уулын зам" ХХК-ийн захирал
2. Нямжавын Адилбиш - Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн авто замын төслийн удирдагч
3. Батчулууны Баясгалан - "Архангай –АЗЗА" ХК-ийн ерөнхий инженер
4. Ламхүүгийн Батцэож - Нийслэлийн Авто замын газрын орлогч дарга





5. Цэрмаагийн Бүрэнтогтох - АЗХСТ-ийн ахмадын хэсгийн өндөр настан
6. Ишжамцын Гончигзэвэг - "Ялгуулсан" ХХК-ийн дэд захирал
7. Жамцын Галбадрах - Хэнтий аймаг дахь Зам засвар арчлалтын "Харгуй" ХК-ийн автогрейдерчин
8. Чүлтэмийн Даринчулуун - "МонАЗ" ХХК-ийн дэд захирал, ерөнхий ня-бо
9. Гүнчингийн Дондов - АЗХСТ-ийн Зам, барилга үйлвэрлэлийн хэлтсийн хэмжилтийн инженер
10. Цэвэлийн Жадамба - Хэнтий аймаг дахь Зам засвар арчлалтын "Харгуй" ХК-ийн жолооч
11. Мухааны Идэр-иш - "Ховд АЗЗА" ХК-ийн мастер
12. Байгарагийн Мандат - "Зүүн чиглэлийн гол зам барих, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл"-ийн удирдагч
13. Алтангэрэлийн Нанзад - "Заабар" ХХК-ийн кассын нярав
14. Хүрэлсүхийн Лхагвасүрэн - "Эрдэнэ зам" ХК-ийн жолооч
15. Цэрэндоржийн Сайнзаяа -Зам барилга, тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний "Сан-Од Хоршоо"-ний ерөнхий менежер
16. Гончигийн Сүхбаатар - АЗХСТ-ийн ахмадын хэсгийн өндөр настан
17. Дугарын Пүрэвсүрэн - Зам барилга, тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний "Сан-Од Хоршоо"-ний ерөнхий инженер
18. Доржийн Пүрэвсүрэн - Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын эрүүл мэндийн даатгалын байцаагч-эмч
19. Долгоржавын Однасан - Нийслэлийн Авто замын газрын өндөр настан
20. Бүүвэйн Минжүүр - Баянзүрх дүүргийн Гачуурт тосгоны өндөр настан, ахмад тээвэрчин
21. Санжидын Цэрэндолгор - "Самон" ХХК-ийн захирал
22. Ванчингийн Чулуунбат - "Өвөрхангай АЗЗА" ХК-ийн өндөр настан
23. Баатарын Эрхэмбаяр - "ГБЭТ" ХХК-ийн захирал
24. Равдан-Очирын Эрдэнэчимэг - "Эрдэнэ зам" ХК-ийн Хөдөлмөр хамгааллын инженер
25. Доохүүгийн Нанзаддорж - Авто замын газрын Замын ашиглалт, засварын удирдлага, хяналтын хэлтсийн дарга
26. Түвдэннямын Ганзориг - "Говь-Алтай АЗЗА" ХК-ийн захирал

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ

1. Лхамжавын Адилбиш - "Эрдэнэ зам" ХК-ийн захирал
2. Лхагвасүрэнгийн Авъяа - "МСРС" ХХК-ийн инженер



3. Ойдовын Алтантуяа - "Эрдэнэ зам" ХК-ийн дэд захирал
4. Ламжавын Аюушмаа - "Эрдэнэ зам" ХК-ийн өндөр настан
5. Нанжидын Бямбахорол - "Саруул жим" ХХК-ийн үйлдвэрлэл хариуцсан инженер
6. Шагдаржавын Болд - "Саруул жим" ХХК-ийн зөвлөх эдийн засагч
7. Равжирын Балжир - "Ай Си Ти Сайн Консалтинг" ХХК-ийн замын зөвлөх инженер
8. Түнжээгийн Батжаргал - "Мон АЗ" ХХК-ийн захирал
9. Чимэддоржийн Батдэлгэр - "Саруул жим" ХХК-ийн ерөнхий инженер
10. Дамчаагийн Баатар - "Дорнод авто зам" ХК-ийн жолооч
11. Нанжидын Бямбахуу - "Ялгуусан" ХХК-ийн менежер
12. Хадаагийн Басан - АЗХСТ-ийн Зам барилга, үйлвэрлэлийн хэлтсийн хяналтын инженер
13. Лувсандагвын Батжаргал - АЗХСТ-ийн Зам барилга, үйлвэрлэлийн хэлтсийн хяналтын инженер
14. Жүгдэржавын Болормаа - АЗХСТ-ийн Зүүн чиглэлийн гол зам барих төслийн нарийн бичиг, операторч
15. Намсрайн Болд-Эрдэнэ - "Хөвсгөл АЗЗА" ХК-ийн гүйцэтгэх захирал
16. Танягийн Булгантамир - АЗХСТ-ийн Дархан-Эрдэнэтийн авто замын төлбөр хураах цэгийн ахлагч
17. Жанжаагийн Билэгсайхан - "Дорнод авто зам" ХК-ийн инженер
18. Бямбажавын Батсуурь - "Хөвсгөл АЗЗА" ХК-ийн нярав
19. Майдаржавын Бямбаа - "Мөнгөн мод" ХХК-ийн захирал
20. Сайнбилэгийн Гэрэлмаа - АЗХСТ-ийн Хүний нөөц сургалт, дотоод мэдээ мэдээлэл хариуцсан ажилтан
21. Шагдарын Ганбаатар - "Төв АЗЗА" ХК-ийн механизмчин
22. Ёндонгийн Гантөмөр - "Архангай - АЗЗА" ХК-ийн автогрейдерчин
23. Мийгаагийн Ганбаатар - "Төв АЗЗА" ХК-ийн захирал
24. Данзангийн Гүнтэв - "Эрдэнэ зам" ХК-ийн автогрейдерчин
25. Сэнгийн Дашжамц - "Дархан АЗЗА" ХК-ийн жолооч
26. Цэдэнсодномын Даваасүрэн - "Хөвсгөл АЗЗА" ХК-ийн хүний нөөцийн ажилтан
27. Түдэвийн Даваа - "Хөвд АЗЗА" ХК-ийн механизмчин
28. Намарлаагийн Ёндон - АЗХСТ-ийн Зам барилга, үйлвэрлэлийн хэлтсийн хяналтын инженер
29. Аюурзанын Жигжидсүрэн - "Мөнхийн тод зам" ХХК-ийн ТУЗ-ын дарга
30. Дагвын Мөнхцэцэг - "Дархан АЗЗА" ХК-ийн замын мастер



31. Гочоогийн Мягмар - "Өвөрхангай АЗЗА" ХК-ийн ерөнхий инженер
32. Халтарын Намсрай - "УБ АЗЗА" ХК-ийн цахилгаанчин
33. Чойжилын Намшир - "Ти Ай Би" ХХК-ийн зөвлөх инженер
34. Батцагааны Нямсайхан - "Орхон зам" ХХК-ийн захирал
35. Пэрэнлэйн Нэрэнхүү - "МСРС" ХХК-ийн инженер
36. Бигазигийн Нэгдалхан - Баян-өлгий аймгийн зам, барилга  
үйлдвэрлэлийн "Жол" ХК-ийн ерөнхий ня-бо
37. Цэрэнхүрэлийн Нямдаваа - "Ялгуусан" ХХК-ийн жолооч
38. Дондовын Наранхүү - АЗХСТ-ийн Зам барилга, үйлвэрлэлийн  
хэлтсийн хяналтын инженер
39. Нацагдоржийн Наранхүү - "Сэлэнгэ АЗЗА" ХК-ийн мастер
40. Дорждамбын Найдан - "Төв АЗЗА" ХК-ийн эдийн засагч
41. Шугаржавын Намжилсүрэн - Дархан АЗЗА ХК-ийн гагнуурчин
42. Банзрагчийн Люба - Авто замын газрын Ахмадын хэсгийн өндөр  
настан
43. Чүлтэмсүрэнгийн Лхагважав - АЗХСТ-ийн лабораторийн эрхлэгч,  
ахлах инженер
44. Агваандандарын Лхамсүрэн - АЗХСТ-ийн нярав
45. Ваннигдоржийн Лхаеий-бумуу - Нийслэлийн Авто замын газрын  
зохион байгуулагч
46. Норовцэрэнгийн Орхон - "Булган АЗЗА" ХК-ийн захирал
47. Пунцагжамцын Отгондалгэр - Авто замын зураг төслийн "Миллениум  
роуд" ХХК-ийн төсөвчин, нярав
48. Шажингийн Оюун - "Булган АЗЗА" ХК-ийн ерөнхий инженер
49. Мягмарын Очирхуяг - АЗХСТ-ийн Зам барилга, үйлвэрлэлийн  
хэлтсийн хяналтын инженер
50. Самбуугийн Олдох - "Дархан АЗЗА" ХК-ийн механик
51. Жамъянсүрэнгийн Өлзийбуян - "Архангай авто зам" ХК-ийн  
механизмчин
52. Гомбодоржийн Өлзийсайхан - Авто замын газрын жолооч
53. Хүрлээгийн Пүрэвдорж - АЗХСТ-ийн Авто замын ашиглалт, засвар  
арчлалтын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
54. Цэрэндоржийн Пүрэвдорж - "Чайлган" ХХК-ийн ерөнхий инженер
55. Нямын Сандагдорж - "Төв АЗЗА" ХК-ийн жолооч
56. Даржавгийн Сүхбаатар - "Дархан АЗЗА" ХК-ийн механизмчин
57. Хяукуны Сураган - "Ховд АЗЗА" ХК-ийн ерөнхий инженер
58. Надмидын Сүхбат - "Ховд АЗЗА" ХК-ийн автогрейдерчин



59. Жамсранжавын Тунгалаг - АЗХСТ-ийн Бичиг хэрэг, архивын эрхлэгч
60. Дашийн Төртогтох - "Хөвсгөл зам" ХХК-ийн Асфальтбетон заводын операторчин
61. Хатайн Хурмет - "Жол" ХХК-ийн автогрейдерчин
62. Самдангийн Цэрэнпил - "Ховд АЗЗА" ХК-ийн жолооч
63. Андгайгийн Цэвээнжав - "Бөөн –Улиас Трейд" ХХК-ийн захирал
64. Тэжмэлийн Цэцэгмаа - "Саруул жим" ХХК-ийн ерөнхий захирал
65. Бадмаанямбуугийн Цэгмид - Авто замын зураг төслийн "Миллениум роуд" ХХК-ийн инженер, хүний нөөцийн ажилтан
66. Даваагийн Цэнджав - "Гангүүр" ХХК-ийн бригадын дарга
67. Чойндонгийн Чанцал - Нийслэлийн Авто замын газрын няраа
68. Дамдингийн Чулуунбаатар - Нийслэлийн Авто замын газрын зохион байгуулагч
69. Ширчингийн Чулуундорж - "Сэлэнгэ АЗЗА" ХК-ийн жолооч
70. Цоодолын Чимгээ - "Өвөрхангай АЗЗА" ХК-ийн үйлдвэрлэл хариуцсан менежер
71. Доржийн Ширэн - Хэнтий аймаг дахь зам засвар арчлалтын "Харгуй" ХК-ийн жолооч
72. Уянгын Эрдэнэбилэг - "Дархан АЗЗА" ХК-ийн гүйцэтгэх захирал
73. Дамдингийн Энхтуяа - АЗХСТ-ийн Зах зээлийн судалгаа, норм үнэлгээ хариуцсан ажилтан
74. Жигмэдийн Энхтүвшин - "Гангүүр" ХХК-ийн ерөнхий ня-бо
75. Жумбагийн Эрдэнэ - "Өвөрхангай АЗЗА" ХК-ийн өндөр настан

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 362

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

"Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэл бэлтгэх журмыг 1 дүгээр, илтгэл хариуцан боловсруулах байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Илтгэл бэлтгэхтэй холбогдуулан тухайн байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих, илтгэлийг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлж байхыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатар даалгасугай.

3. Илтгэлийг боловсруулахад швардагдах хөрөнгийг жил бүр төсвийн багцдаа тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, Авлигатай тэмцэх газар (Ч.Сангарагчаа)-т зөвлөсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монгол Улсын нэгдэж орсон Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн илтгэл бэлтгэх төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 39 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

**Г.ЗАНДАНШАТАР**

Засгийн газрын 2009 оны 362 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН  
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ  
ИЛТГЭЛ БЭЛТГЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэл бэлтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## Хоёр. Илтгэл бэлтгэх ажлыг зохион байгуулах

2.1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэл хариуцан боловсруулах байгууллага батлагдсан хуваарийн дагуу бэлтгэх, "Үндэсний илтгэл хариуцан боловсруулах байгууллагын жагсаалт"-д ороогүй илтгэлийг тухайн конвенциор зохицуулж байгаа асуудал, салбарыг хариуцсан байгууллага бэлтгэх үүргийг хүлээнэ. Тухайн конвенциор хэд хэдэн салбарын асуудлыг зохицуулж байгаа тохиолдолд уг асуудлыг голлон хариуцах байгууллага илтгэл боловсруулах ажиллагаанд тэргүүлэх үүрэгтэйгээр оролцоно.

2.2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэл (цаашид "Илтгэл" гэх) бэлтгэх ажлыг тухайн илтгэлийг хариуцан боловсруулах байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг (цаашид "ажлын хэсэг" гэх) зохион байгуулна. Ажлын хэсэг нь тухайн илтгэлийг хариуцан боловсруулах байгууллагын удирдлагын шууд удирдлага дор үйл ажиллагаа явуулна.

2.3. Илтгэл бэлтгэхтэй холбогдон гарах аливаа зардал (бичиг хэрэг, албан ёсны орчуулга гэх мэт)-ыг тухайн байгууллагын төсвөөс гаргана. Илтгэл бэлтгэхэд олон улсын болон хандивлагч байгууллагаас санхүүгийн дэмжлэг авч болно.

2.4. Илтгэлийн төслийг бэлтгэхтэй холбогдуулан гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага бусад яам, газраас мэдээлэл, баримт материал, судалгаа гаргуулах буюу мэргэжлийн зөвлөгөө авч болно. Илтгэл бэлтгэхэд эрдэмтэд, мэргэжилтэн, тухайн асуудлыг эрхэлсэн төрийн бус байгууллагын саналыг аль болох авч, илтгэлд тусгах чиглэл баримтална.

2.5. Үндэсний илтгэл бэлтгэх хуваарь, хүлээгдэж байгаа ээлжит илтгэл, тухайн гэрээ болон конвенцийн талаархи ерөнхий мэдээлэл, лавлагааг Гадаад харилцааны яам хариуцан бэлтгэнэ.

2.6. Илтгэл бэлтгэх байгууллага нь тухайн илтгэлийн төслийг холбогдох олон улсын байгууллагаас тавьсан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн гарсан шийдвэрийн биелэлтийг шуурхай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж байна.

## Гурав. Илтгэлийг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх

3.1. Үндэсний илтгэл бэлтгэх ажлын явцад Гадаад харилцааны яам хяналт тавьж ажиллана. Засгийн газраас дэмжсэн илтгэлийг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

### Дөрөв. Илтгэлийг хэлэлцүүлэх

4.1. Илтгэлийг холбогдох олон улсын байгууллагаар хэлэлцүүлэх (хамгаалах) асуудлыг тухайн илтгэлийг хариуцан боловсруулсан байгууллагын удирдлага (сайд, дэд сайд буюу дарга, төрийн нарийн бичгийн дарга) хариуцна. Сангийн яам төлөөлөгчдийн зардал (зам хоног, зочид буудал)-ыг холбогдох байгууллагын тухайн жилийн гадаад арга хэмжээний зардалд тусгана.

4.2. Илтгэлийг хэлэлцээд гаргасан олон улсын байгууллагын зөвлөмжийн биелэлтийг тухайн илтгэлийг хариуцан боловсруулсан байгууллага зохион байгуулна.

4.3. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн тухай Үндэсний илтгэлийг тогтоосон хугацаанд нь бэлтгэн явуулах үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан тушаалтанд зохих журмын дагуу хариуцлага тооцно.

Засгийн газрын 2009 оны 362 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

### ҮНДЭСНИЙ ИЛТГЭЛ ХАРИУЦАН БОЛОВСРУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Конвенц	Байгууллага
1	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	ХЗДХЯ, ГХЯ
2	Алартеидийн гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц	ГХЯ
3	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	ХЗДХЯ



4	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц	ХЗДХЯ
5	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	НХХЯ, БСШУЯ, ЭМЯ
6	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	НХХЯ
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц	НХХЯ
8	Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц (түүний 146 дугаар зөвлөмж)	НХХЯ
9	Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенц	НХХЯ
10	Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц (түүний 111 дүгээр зөвлөмж)	НХХЯ
11	Хүүхдийн эрхийн тухай конвенц	Шадар сайдын ажлын алба, Хүүхдийн төлөө газар
12	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	Шадар сайдын ажлын алба, Хүүхдийн төлөө газар
13	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	Шадар сайдын ажлын алба, Хүүхдийн төлөө газар
14	Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц	БОАЖЯ
15	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц	БОАЖЯ



16	Амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц	БОАЖЯ
17	Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц	ЭМЯ
18	Тамхины хяналтын тухай суурь конвенц	ЭМЯ
19	Мансууруулах эмийн тухай конвенц	ЭМЯ
20	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус аргалтийн эсрэг конвенц	ЭМЯ
21	Авлигалын эсрэг НҮБ-ын конвенц	АТГ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 364

Улаанбаатар  
хот

### Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар хооронд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологи, спортын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР


#### Хянг:

"Төрийн мэдээлэл" мөхтгэлийн редакци  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: tunin\_medceel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэгдэв.  
Утас 329487